



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 02 сарын 27 өдөр

Дугаар А/М/2

Алтай хот

Гэрээ байгуулах эрх олгох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, 46.3 дахь хэсэг, Үнэлгээний хорооны 2023 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 05 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх Нэгдсэн эмнэлэгт эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх ГААОНӨГ/202301026 дугаартай тендерт оролцож шалгарсан, хавсралтад заагдсан компаниудтай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх эрхийг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал)-т олгосугай.

2. Гүйцэтгэгчийн нийлүүлэхээр санал болгосон ажлын даалгаврыг үндэслэн холбогдох хууль журмын дагуу эрх, үүрэг, захиалагчийн хяналт, хариуцлагыг гэрээнд тодорхой тусгаж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тайлагнаж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал)-т үүрэг болгосугай.

3. Ажлын гүйцэтгэл, санхүүжилтэд хяналт тавьж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Х.Баатарзориг), Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнхжаргал), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Г.Хурцгэрэл), Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ОРЛОГЧ



Г.ЧИНБАТ

Аймгийн Засаг даргын 20²³ оны 0⁰
дугаар сарын 0⁰-ны өдрийн 0⁰ дугаар
захирамжийн хавсралт

ГЭРЭЭ БАЙГУУЛАХ КОМПАНИУДЫН НЭР

Д/д	Компанийн нэр	Сонгосон багцын дугаар
1.	"Монос трейд" ХХК	2, 3А, 4, 12, 16
2.	"Монфа трейд" ХХК	8
3.	"Энто" ХХК	6А, 6Б, 14Б, 15
4.	"Айвейко хелт кейр" ХХК	11
5.	"Монбио фарм" ХХК	27, 29, 33
6.	"Гүн тэнгэрийн нар" ХХК	18А
7.	"Мөнхийн тун" ХХК	22А, 24
8.	"Монгол фарм" ХХК	28
9.	"Сүвэн уул" ХХК	19
10.	"Ази фарм" ХХК	7
11.	"Их шүүдэргэнэ" ХХК	13
12.	"Агниста фарм" ХХК	14А
13.	"Тавин ус" ХХК	22Б
14.	"Медиконт" ХХК	23А, 23Б
15.	"ДЕС" ХХК	26
16.	"Мөнгөн гөлтгөнө" ХХК	21
17.	"Сетунари" ХХК	31, 32

Аймгийн Засаг даргын 2023 оны
02.. дүгээр сарын 01-ны өдрийн 01/02 дугаар
захирамжийн нэгдүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ХОШОЙ АВАРГА БОЛОН АВАРГА МАЛЧИН,
ТАРИАЛАНЧААР ШАЛГАРСАН ХҮМҮҮСИЙН НЭРС**

“МОНГОЛ УЛСЫН ХОШОЙ АВАРГА МАЛЧИН”-ААР ШАЛГАРСАН МАЛЧИН

№	Эцэг, эхийн нэр	Өөрийн нэр	Сумын нэр	Багийн нэр
1	Жамъяаншарав	Лоохууз	Тонхил	Алтан Оргил
2	Цагаачийн	Батбямбаа	Чандмань	Өлзийбулаг

“УЛСЫН АВАРГА МАЛЧИН”-ААР ШАЛГАРСАН МАЛЧИН

№	Эцэг, эхийн нэр	Өөрийн нэр	Сумын нэр	Багийн нэр
1	Дэндэв	Мөнх	Баян-Уул	Чандмань хайрхан
2	Гэсэр	Оросоо	Халиун	Гүү бариач
3	Охин	Батаа	Цээл	Бүрэнжаргалан
4	Ногоон	Нанжид	Бугат	Биж
5	Чилхаа	Довчин	Чандмань	Өлзийт
6	Санжжав	Даваажав	Хөхморьт	Завхан гол
7	Наранцэцэг	Сүрэнхорол	Дэлгэр	Баян буурал
8	Пэрэнлэй	Ганбаатар	Шарга	Сондуулт

“УЛСЫН АВАРГА ТАРИАЛАНЧ”-ААР ШАЛГАРСАН ТАРИАЛАНЧ

№	Эцэг, эхийн нэр	Өөрийн нэр	Сумын нэр	Багийн нэр
1	Мухар	Нямсүрэн	Бугат	Биж

__оОо__

Аймгийн Засаг даргын 2023 оны
02 дугаар сарын 24-ны өдрийн 11/02 дугаар
захирамжийн гуравдугаар хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

Д/СД00642

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт үнэ
1.	Уут	30 ширхэг	4,500	135,000
2.	Ноолууран ороолт	30 ширхэг	98,900	2,967,000
3.	Дээлийн өнгө, торго	11 ширхэг	312,800	3,440,000
4.	Календар	30 ширхэг	5,000	150,000
5.	Хүндэт Өргөмжлөл	11 ширхэг	55,000	605,000
6.	Өргөмжлөл	19 ширхэг	20,000	380,000
7.	Чихэр	30 ширхэг	26,000	780,000
Нийт дүн				8,457,000

__оОо__